

УДК 930.85+24

ШАР ЦОРЖИЙН НАМТАР БҮТЭЭЛИЙГ СҮВЭГЧЛЭХҮЙ

Наранцэцэг Д.

доктор (Ph.D), профессор

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн

Улаанбаатар, Монгол Улс

E-mail: narantsetseg_d@mas.ac.mn

Хураангуй

Намтар бол Төвдийн оюун санааны утга зохиолын төрөл зүйл бөгөөд Дарма (заах) зам дээр ахиц дэвшлийн тухай өгүүлдэг. Оюун санааны намтар буюу агиографи бөгөөд *нампар тарпа* (Tib)-аас товчилсон нэр юм: ལྷན་པར་ཐར་པ་, *nam par thar pa*), энэ нь шууд утгаараа 'бүрэн чөлөөлөлт' гэсэн утгатай. Монголчуудын төвөд хэлт утга зохиолын хөгжилд жинтэй хувь нэмэр оруулсан зохиолчдын нэг нь Халхын Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошууны Баян овоо хийдийн лам, Шар цорж хэмээн олноо алдаршсан Дагважанцан (1855-1927) юм. Шар цоржийн бие даасан намтар гэж үгүй бололтой. Бид түүний бичсэн зан үйлийн ном зохиолыг хараахан олж чадаагүй хэдий ч тэрбээр төвөд хэлээр шүлэглэн бичсэн Монголын 8 богдын 9 намтар, солдэв болоод монгол хэлээр бичсэн Шударга дөлгөөн хааны зохиосон шүлэг маани зэрэг зохиолыг бичсэн нь тодорхой болоод байна. Судалгааны сэдвийн ач холбогдол нь Монголын бурханы шашны түүхэнд ул мөрөө үлдээсэн Дагважанцангийн намтрыг судлах шаардлагатай байгаатай холбоотой юм. Энэ асуудлыг шийдэх нь Монгол дахь шашны болон түүхэн үйл явцыг ойлгоход чухал ач холбогдолтой.

Түлхүүр үг

Шар цорж, монголын төвөд хэлт утга зохиол, намтар зохиол.

UDC 930.85+24

IN SEARCH OF THE BIOGRAPHY AND WORKS OF SHAR TSORJ

D. Narantsetseg

Ph.D., Professor

Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences

Ulaanbaatar, Mongolia

E-mail: narantsetseg_d@mas.ac.mn

Annotation

A biography is a Tibetan spiritual literary genre that tells about progress on the path of Dharma (teaching). It is a spiritual biography or hagiography, and is an abbreviation of *nam par thar pa* (Tib: ནམ་པར་ཐར་པ་ *nam par thar pa*), which literally means ‘complete liberation’. One of the writers who made a significant contribution to the development of Tibetan literature among the Mongolians was Dagvajantsan (1855-1927), a lama of Bayan Ovoo Monastery in the Gobi Munban Wang district of the Tusheet Khan aimag of Khalkha, popularly known as Shar Tsorj. There seems to be no independent biography of Shar Tsorji. Although we have not yet found any ritual literature written by him, it is clear that he wrote the 9 biographies of the 8 Mongolian bogdos in verse in Tibetan, the *soldev*, and the *suleg maani* composed by Shudarga Dulgun Khan in Mongolian. The importance of the research topic is due to the need to study the biography of Dagvajantsang, who left his mark on the history of Mongolian Buddhism. Solving this problem is important for understanding religious and historical processes in Mongolia.

Key words

Shar Tsorji, Mongolian Tibetan literature, biography.

О Р Ш И Л

Академич Д. Цэрэнсодном багш тэртээ 1988 онд “Эдүгээ дэлхийн том том номын сангуудад /Ленинград, Бээжин, Копенгаген, Геттинген, Марбург зэрэг/ хадглагдаж буй монгол номын бүртгэл судалгааг гадаадын монголч эрдэмтэд бараг бүрнээр хийж, судалгааны хүрээнд оруулсаар байхад голомтон дээрээ сууж байгаа бид “авдрандаа буй алтныхаа” хэмжээг нарийн мэдэхгүй байх нь даанч харамсалтай хэрэг юм” (Цэрэнсодном, 1988; Бямбаа, 2004а: 26) хэмээн монгол номын бүртгэл судлалтай холбогдуулан хэлсэн нь монголчуудын төвөд хэлээр бичсэн ном бүтээлд нэгэн адил хамаарах үг бөгөөд энэ чиглэлийн судалгааг урагшлуулах ажлыг манай эрдэмтэн судлаачид зохих төвшинд хийсээр байна. Намтар нь Буддын шашны бичгийн уламжлалын чухал төрөл зүйл юм (Willis, 1985; Монголын сүм хийдийн түүхэн товчоон, 2009; Омакаева, 2010). Энэ бол багшийн намтрыг харуулсан агиографийн төрөл юм (Дылыкова, 2015; Туранская, 2015; Шиманская, 2014).

Бид ч төвөд хэлээр ном зохиол туурвисан монгол эрдэмтдийн намтар бүтээлийг тодруулах, шинжлэн судлах үүднээс Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошууны Шар цорж хэмээн олноо алдаршсан Дагважанцан ламын тухайд өөрийн олж мэдсэнээ доор толилуулъя. Түүний тухай номч мэргэн хамба С. Гомбожав 1959 онд бичсэн “Монголчуудын төвөдөөр бичсэн зохиолын зүйл” өгүүлэлдээ: “Дагважанцан Говь мэргэн вангийн хошууны Шар цорж хэмээн алдаршсан. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, зан үйл, залбирал, мөргөл зэрэг, гар бичмэл” (Gombojab, 1959: 22) хэмээн тэмдэглэсэн байдаг.

Шар цоржийн бичсэн Өндөр гэгээний намтар

Өндөр гэгээний намтар «Тийн удирдагч Жэвзүндамба их эрдэнийн намтар магтаал хувь сайтын сүсгийг сэлбэрүүлэгч оршвой»¹ хэмээх зохиолын төгсгөлийн үгэнд:

རང་ལ་ཡོན་ཏན་མེད་ཀྱང་འདི་འདྲ་ཞིག །
 སྤེལ་འོས་མེན་ཀྱང་གདལ་བྱ་གཅིག་གིས་ཀྱང །
 ལྷགས་མགོན་ཆེན་པོ་རྩེས་སྤྱད་པ་ཡི། །
 རྩེན་ད་ལྱམ་ན་ལྷན་པའི་སྤོན་ཡིད་ཀྱིས། །
 རྩོག་གྲུན་མཁྱེན་མཐ་ཆེན་སྟོབས་ལྡན་རྩེ། །
 རྩོམ་མཛད་པ་སྟོན་པའི་དབྱེས་མཆོད་ལ། །
 རྩོམ་གལས་གནས་སྟུང་ཀུ་ཀའི་ཉེ་འདབས་སྟུ། །
 རྩོམ་འདི་ལྷན་པའུབས་འཁོས་མེད་ཀྱི་རྩེ་ཡིས། །
 རབ་བྱང་བཅོ་ལྔའི་ནང་གི་ཡོངས་འཛིན་ཞེས། །
 རུ་བྱ་ལོ་ལྟ་བུ་ལྷེད་མར་དོན་ས། །
 རུམ་མས་ཉེ་ས་གླ་པའི་ཆོས་ཉར་ལ། །
 རུད་རྩེ་སྟོན་པ་ལྡན་ཉིན་རྩོགས་པར་བྱས། །

«Өөрт эрдэм үгүй миний мэт

Өгүүлэх зохисгүй боловч шавь нэгэн бээр

Өндөр богдын хойноос даган дүүдахын шалтгаан болгон

Ил далд хамгийг айлдагч чадал хүчин төгс богдын

Илт гайхамшигт зохиол намтрыг үзүүлэн баясган тахиж

¹ གྲུ་འདྲེན་རྩེ་བཅའ་དམ་པ་རིན་པོ་ཆེའི། རྒྱལ་ཁབ་བསྐྱོད་ཆིག་རྒྱལ་བཟང་དང་གསོལ་བཞུགས།

Үнэн мэргэдийн орон Өлгий хийдийн ойролцоо
Үтэл ичгүүргүй молхи Гирди бээр
Арван тавдугаар жарны огоот баригч хэмээх
Усан хулгана жилийн нага сарын хуучаар эхэлж
Барин тавьсаар сага сарын хорин тавнаа
Рашааны барилдлагат өдөр гүйцээн бичив»

гэж буй нь энэ зохиолыг самгардиар **Гирди**, төвөдөөр **Дагба** буюу **Дагбажанцан** нэрт лам арван тавдугаар жарны огоот баригч хэмээх усан хулгана жил, аргын тооллын 1912 оны хаврын адаг сарын сүүлчээр эхэлж, зуны эхэн сарын хорин таванд, Өлгий хийдийн орчим бичиж дүүрснээ хэлжээ.

Өлгий хийд нь Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошуу, одоогийн Дорноговь аймгийн Мандах сумын нутагт Сайшаалт ерөөлтийн долоогоос аравдугаар оны хооронд буюу аргын тооллын 1802–1806 онд Өлгий уулын энгэрт байгуулсан хийд бөгөөд Тавдугаар богд Жэвзүндамба хутагтаас (1815–1841) Жанчүвтэгчэнлин хэмээх нэр хайрласан гэдэг. Өлгий хийд нь цогчэн, манба, чойр, дүйнхор, ламрим зэрэг төрөлжсөн сургалт явуулдаг дацангуудтай, 1000 гаруй ламтай, Монгол орон даяар гайхагдсан олон эрдэмтэй лам нар энэ хийдэд хурж, нямба бясалгал үйлдэн, бүтээл номоо бичиж туурвисны нэг нь Шар цорж Дагбажанцан билээ.

Шар цоржийн бичсэн Өндөр гэгээний энэ намтрыг доктор Ш. Сонинбаяр ламтан 1995 онд үргэлжилсэн үгийн хэлбэрээр орчуулж хэвлүүлсэн бөгөөд тэрбээр: «Өндөр гэгээний намтар «Тийн удирдагч Жибзундамба их эрдэнийн намтар магтаалын үг сайн хувьтны сүсгийг сэргээгч оршвой» зохиолыг XX зууны эхэн үеийн шашны сонгодог боловсролтон, олонд Шар цорж гэж алдаршсан Дагважанцан 1912 онд төвөд хэлээр зохиожээ. Шар цорж Дагважанцан нь хуучин Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошууны /Одоогийн Дорноговь аймгийн Сайхандулаан сум/ хүн юм. Дагважанцан бага наснаасаа өөрийн хошууны гол хийд Өлгийд шавилан сууж, шашны олон зүйл эрдэм ухаан, ялангуяа буддын гүн ухааныг судалсан байна. Тэрээр төвөд хэлээр зохиол бүтээл туурвисны дотор элдэв жижиг залбирал, магтаал, түүх зэрэг номууд байдаг. Эл орчуулсан намтар нь барын болон бичмэлээр цөөвтөр хувь байдаг. Уг намтар зохиол нь утга хураангуйн гадна олон мэргэдийн номоос эшлэл татсан зэрэг нь орчуулах явцад нэлээн бэрхшээлтэй байлаа» (Сонинбаяр, 1995: 2) хэмээн тодлон өгүүлжээ. Номын төгсгөлд:

«Номын хаан ачит Өндөр гэгээний
Номын явдлыг үзүүлсэн энэ намтрыг
Номын орон Түвдэндаржайлин хийдэд

Номын өглөгийг арвижуулахын тулд хэвлэн бүтээв» (Сонинбаяр, 1995: 52) гэж буй.

Номын төгсгөлийн энэ үг бидний толилуулан буй гар бичмэл эхэд үгүй. Эндээс бид Шар цоржийн зохиол бүтээл С. Гомбожав хамбын дурдсанчлан гар бичмэлээр байхаас гадна, төвөд монгол хэлээр зохиосон зарим зохиолыг нь Түвдэндаржайлин хийдэд барлан гаргасан болохыг мэдэж болно. Тухайлбал, Шар цоржийн туурвисан өөр нэгэн зохиол болох «Наймдугаар богдын залбирал¹»-ын төгсгөлийн үгэнд:

ཆེས་ཀྱི་རྒྱལ་པོ་རྩེ་ཡི་གསོལ་འདེབས་འདི།
 ཆེས་ཀྱི་དམ་པའི་མགོན་པོ་རང་ཉིད་ནས།
 ཆེས་ཀྱི་ཉི་འོད་ཆེས་ཆེར་གསལ་མཛད་ལྱིར།

¹Skyabs gnas mthar thug skyabs mgon brgyad pa la// skyabs ‘ch’a gsol ‘debs skyabs gnas ngo shes
bzhugs// гар бичмэл, 3 хуудас

ཆེས་སྲིད་ཟུང་བྱ་འཛིན་པའི་དགའ་སྟོན་བྱ།

ཆོས་ཀྱི་རྩེ་ལ་སྒྲིང་ནས་མོས་པ་ཡི།

ཆོས་མེད་རྒྱལ་མཚན་ཟེར་བའི་བྲལ་བོར་བས།

ཆོས་སྡེ་ཐུབ་བསྟན་དར་རྒྱས་སྲིང་ན་གྱིས།

ཆོས་ཚུལ་ཡུན་རིང་གནས་པའི་རྒྱ་རྒྱུ་ཅིག །

Номын хаан богдын залбирал үүнийг

Номын богд дээд итгэл түүнээс

Номын нарны гэрлийг ихээс ихэд гийгүүлэн зохиохын тулд

Ном төрийг хослон баригчийн баясгалант хуримд

Номын богдод зүрхнээс биширсэн

Номгүй **Жанцан** хэмээх ичгүүргүй нэгэн бээр

Номын хийд Түвдэндаржайлинд бичив

Номын ёс өнөд оршихын шалтгаан болтугай» хэмээж буй. Үүнээс бид Жанцан нэрт буюу Дагбажанцан лам тус зохиолыг Түвдэндаржайлин хийдэд бичсэнийг тодорхой харж болно.

Энд гарч буй Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошууны нутаг дахь Түвдэндаржайлин хийд нь Эрдэнэ-Овоогийн хурал мөн эсэхийг тодруулуштай Баян-Овоогийн хийд буюу Эрдэнэ-Овоогийн хурлын талаар «Монголын сүс хийдийн түүхэн товчоон» номд «Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошуу, одоогийн Дорноговь аймгийн Сайхандулаан сумын нутагт Тэнгэр тэтгэгчийн хоёрдугаар он, аргын 1734 онд Эрдэнэ да лам байгуулжээ. Тус хурал нь цогчэн дуган, манба, дүйнхор, зод, чойр дөрвөн дацантай, байнга хурал хурдаг 70 шахам ламтай байжээ. Баян-Овоогийн Шар цорж гэж алдаршсан Дагважанцан лам нь төвөд хэл дээр нэг боть ном зохиосон гэдэг. Ялангуяа түүний зохиосон Өндөр гэгээний намтар нь ихэд алдаршсан байна (МСХТТ, 2009:379)» гэж бичсэн байдаг.

Хэл зохиолын хүрээлэнгийн хүндэт доктор, ахмад эрдэмтэн Р. Отгонбаатар, ОХУ-ын монголч эрдэмтэн, доктор (Sc.D) профессор А.Д. Цендина нар «Монгол үсэг бичгийн дээж» бүтээлдээ Шар цоржийг «1926 оны орчим, 70 эргэм насандаа таалал төгсжээ» (Отгонбаатар, Цендина, 2014: 155) хэмээгээд, түүнийг өнөө хэр нь мэдэгдээд байгаа монгол хэлээр, төвөд бичгээр бүхэлд нь бичиж хэвлэсэн цор ганц барын бүтээл болох «Шударга дөлгөөн хааны зохиосон шүлэг маани сэлт оршив» хэмээх маани хөгжөөх шүлгийг эх монгол хэлээрээ зохиож, Эрдэнэ-Овоо (Баян-Овоо) хийдэд барласан болохыг анхлан мэдээлж, уг маанийг бүрэн эхээр нь оруулсан байна. Энэхүү маани хөгжөөх шүлгийн төгсгөлд:

ཨེ་ནེ་མ་ཁི་ནུ་ནེ་རེ་ནི། །

ཨཱ་ནི་ལྷོ་ཨཱིག་པ།

ཨེརྟེན་ཨོ་པོ་གི་སྒྲུལ་བློ་རེ།

ཨེབ་ལཱུ་ལང་རྟེལ་བ་ཅི་ཡུརྟེ་བཅ། །

Энэ маанийн нэр нь

Эрдэнэ лянхын эгшиг буй

Эрдэнэ-Овоогийн лам бээр

Эвлүүлэн холбож ерөөв (Отгонбаатар, Цендина, 2014: 159) хэмээн Эрдэнэ-Овоо хийдийн лам гэдгээс үндэслэн түүнийг Шар цорж бичсэн болохыг сурвалжлан тогтоожээ.

Мөн судлаач Р. Бямбаа ламтан Дорноговь аймгийн нутгаар биечлэн сурвалжлан явж, Шар цорж Дагбажанцаны амьдарч байсан цаг үеийг нь нутгийн иргэдийн аман мэдээ, тухайн цаг үед болсон түүхийн баримт сурвалжид тулгуурлан 1855–1927 онд амьдарч байсан (Бямбаа, 2004а: 1) болохыг тодолох байдаг.

Бид эдгээр баримтад тулгуурлан Шар цоржийг 1920-оод оны сүүл болтол амьдарч, 1912 онд Өндөр гэгээний намтрыг Дундговь аймгийн Сайхандулаан сум буюу хуучнаар Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошууны нутаг Өлгий хийдийн ойролцоо бичиж, Түвдэндаржайлин хийдэд барласан гэж үзээд, энэ хийд орны лам нарт холбогдох Үндэсний төв Архивт хадгалагдаж байгаа хоёр дансыг шүүж үзлээ.

Эхний данс нь “Түшээт хан аймгийн Чуулган даргын фондын баримтын бүртгэл (1911–1921)” цэс болох *Фонд А11, Д. 2* цэснээс 11 Хн баримт, хоёрт нь “Түшээт хан аймгийн Чуулган даргын фондын баримтын бүртгэл (1911–1921)” цэс болох *Фонд А11, Д.1*-ээс 8 Хн баримтыг шүүж үзэв. Үүнийг жагсаавал:

1. Үндэсний төв архивын Түшээт хан аймгийн Чуулган даргын фондын баримтын бүртгэл (1911–1921) цэс болох *Фонд А11, Д2*-оос үзсэн 11 баримт нь:

1. *Фонд А11, Д. 2. Хн 30*

Өртөөг сэлбэх, ацаг хөлсийг гаргуулах, илүү хаасан хоногийг тодорхойлох, Цорж хувилгааны буцах улааг нийлүүлэх зэрэг асуудлаар харилцсан бичиг. 1911. 45

2. *Фонд А11, Д. 2. Хн 116*

Хурал ном, сүм дуганы үйлд алба оногдуулах, мөнгө хандивлах зэрэг асуудлаар харилцсан бичиг. 1913. 14

3. *Фонд А11, Д. 2. Хн 268*

Хошуудад байгаа хутагт, хувилгаад, лам нарын нэр, цол зэргийг тодорхойлон мэдүүлэх, сул лам нарыг бүртгэх зэрэг асуудлаар харилцсан бичиг. 1916. 17

4. *Фонд А11, Д. 2. Хн 374*

Мэргэн вангийн хошууны Үүд-Өлзийт сүмийн жасаас алба гаргуулахгүй байлгах, Дэчинравжайлин сүмийн лам нарыг хэвээр суулган, өрх амын тоог тодорхойлох тухай бичиг. 1918. 2

5. *Фонд А11, Д. 2. Хн 432*

Мэргэн вангийн хошууны Түвдэндаржайлин сүмийн лам нараас албан томилогүй, сүрэг малаас улаа шүүс хэрэглэхгүй байх, Ганжуурын бар сийлэх зэрэг асуудлаар харилцсан бичиг.

6. *Фонд А11, Д. 2. Хн 444*

Тамгатай хутагт, хувилгаадын шавийн зайсангуудын уг хөрөнгөд олон хошуудын түшмэлд адил хагас хувийн алба гаргуулах тухай харилцсан бичиг.

7. *Фонд А11, Д.2. Хн 457*

Ноёд, лам нар, түшмэл нарын уг эх, гавьяа хэргэм зэргийг тодорхойлох, зэрэг залгамжлах хүүхдийг тодорхойлсон тухай бичиг. 1920. 5

8. *Фонд А11, Д. 2. Хн 499*

Ноёд, тайж, хувилгаан лам нарын уг эхийг тодорхойлох тухай бичиг. 1921. 18

9. *Фонд А11, Д. 2. Хн 536*

Түшээт хан аймгийн ноёд, лам нарын нэр зэргийг тодорхойлсон тухай бичиг. 1921. 2

10. *Фонд А11, Д. 2. Хн 432*

Зарлигийг дагаж тэдний хошууны Түвдэндаржайлин сүмийн лам нараас албанаа томилох ба сүрэг малаас улаа шүүс үл хэрэглүүлэх учир улмаар тушаасан эх.

11. Фонд А11. Д. 2. Хн 374

Мэргэн жүн ван Цэсэнжав нарт тус хошууны Үүрд-Өлзийт сүмийн жасаас аливаа алба гаргуулж үл болохыг буулгасан зарлигийн ёсоор дагаж шийтгүүлсэн тушаасан эх.

II. Үндэсний төв архивын “Түшээт хан аймгийн Чуулган даргын фондын баримтын бүртгэл (1911-1921)” цэс болох *Фонд А11. Д.1-ээс шүүж үзсэн 8 баримт нь:*

1. Фонд А11. Д. 1. Хн 344

Түшээт ханы хошууны хутагт лам нар орон дацан, аймаг, жасын мал хариуцагчдын хариулсан малын бүртгэл. 1918.82

2. Фонд А11. Д. 1. Хн 346

Тус аймгийн Мэргэн засгийн хошууны хүн өрх, малын дэлгэрэнгүй бүртгэл. 1918. 50

3. Фонд А11. Д. 1. Хн 347

Мэргэн засгийн хошууны сүм хийд, хурал жасын малын тоог адуулагчдын нэрийн дор гаргасан бүртгэл. 1918. 112

4. Фонд А11. Д. 1. Хн 348

Тус аймгийн Мэргэн засгийн хошууны хүн амын дэлгэрэнгүй бүртгэл. 1918.25

5. Фонд А11. Д. 1. Хн 349

Тус аймгийн Мэргэн засгийн хошууны бүх өрх ам, малын дэлгэрэнгүй бүртгэл. 1918

6. Фонд А11. Д. 1. Хн 350

Тус аймгийн Мэргэн засгийн хошууны бүх өрх ам, малын дэлгэрэнгүй бүртгэл. 1918. 64

7. Фонд А11. Д. 1. Хн 359

Тус аймгийн Ачит засгийн хошууны бүх өрх, хүн ам, мал, бас хурал жасын малын дэлгэрэнгүй бүртгэл. 1918. 9

8. Фонд А11. Д. 1. Хн 364

Тус аймгийн Дархан, Ачит засгийн хошуу нутагт сууж байгаа өөр аймаг хошууны өрх ам, мал, бас сүм жасын мал зэргийг тодорхойлсон данс. 1918. 16.

Архивын эдгээр дансыг нягтлан шүүж үзсэн боловч харамсалтай нь одоогоор Шар цорж Дагважанцанд холбогдох мэдээ баримт хараахан гарч ирсэнгүй, бид лавшруулан Шар цорж, Дагбажанцан, Дагба, Жанцан нэрээр хайж үзэж буй.

Цорж Дагбажанцан нь ард олны дунд голчлон Шар цорж нэрээрээ алдаршсаныг эрдэмтэн III. Сонинбаяр, Р. Бямбаа, Р. Отгонбаатар нар зохиол бүтээлдээ дурдсан байдаг.

Харин доктор О. Сүхбаатар “Монголын тахилгат уул усны сангийн судар оршвой” бүтээлдээ “Олны дунд Шар цорж нэрээр алдаршсан Агваандорж нь “Молон тойны домгийг төвөд хэлээр товчлон бичиж хэвлүүлсэн юм” (Сүхбаатар, 2001: 46) гэж байх боловч энэ нь Бичээч цорж хэмээн алдаршсан Агваандоржийг Шар цорж хэмээн ташаарсан бололтой. Учир нь “Молон тойн өөрийн эхийн ачийг хариулсан ёсон”¹ хэмээх зохиол бол бичээч цорж Агваандоржийн зохиол бөгөөд түүний сүнтөрвуд буй. Мөн бичээч цорж Агваандорж (1785–1849) нь Сэцэн хан аймгийн харьяа Богдын Их шавийн нутагт мэндэлсэн хэдий ч, бага наснаасаа Их хүрээнд шавилан сууж, ном эрдэмд мэргэжээд, Их хүрээний цоржийн албыг хашиж байсан учраас

¹Tib: chos rje tshe ring gis mdzad pa ‘dul ba’i skor las mo dgal gyi bus rang gi ma yi drin gso tshul// Их хүрээний модон бар, 4 хуудас.

олонд Их хүрээний цорж Агвандорж, Бичээч цорж Агванцэрэн, Бичээч цорж, Да хүрээ цорж, Шавдүн цорж гэх нэрээр алдаршсан (Бямбаа, 2004b: 627) ба Шар цорж гэж нэрлэгдэж байсан өөр мэдээлэл олж үзсэнгүй.

Шар цоржийн талаар сурвалжлан нутаг усаар нь явж түүний намтрыг тодруулахыг хичээж байсан эрдэмтдийн судалгаа, аман эх сурвалжид үндэслэвэл Дагбажан-цан лам төвөд, монгол хэлээр хэд хэдэн бүтээл хэвлүүлжээ. Тухайлбал, Монголын Жэвзүндамба хутагтуудаас анхдугаар богд Лувсанданбийжанцаны намтар¹, анхдугаар богд Өндөр гэгээн Занабазарын намтар солдэв², хоёрдугаар богд Жэвзүндамба хутагт Лувсанданбийдонмэгийн намтар³, гуравдугаар богд Жэвзүндамба хутагт Ишданбийнямын намтар⁴, дөрөвдүгээр богд Лувсантүвдэнванчүгжигмэджамцын намтар⁵, тавдугаар богд Жэвзүндамба хутагт Лувсанцүлтимжигмэдданбийжанцаны намтар⁶, зургаадугаар богд Жэвзүндамба хутагт Лувсанбалданданбийжанцаны намтар⁷, долдугаар богд Жэвзүндамба хутагт Агванчойживанчүгпринлайжамцын намтар⁸, наймдугаар богд Жэвзүндамба хутагт Агванлуvsанчойжинямаданзинванчүгийн залбирал⁹ болон Тавдугаар богдын ирээдүйг эш үзүүлсэн лүндэн¹⁰ зохиолыг төвөд хэлээр шүлэглэн бичжээ. Эдгээр гар бичмэл ном Гандантэгчэнлин хийдийн Нацагдорж унзадад байсныг Р. Бямбаа ламтан нэгтгэн «Монголчуудын төвөд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл» Монгол билиг цувралынхаа V боть болгон хэвлэсэн билээ.

Шар цорж мөн «Шударга дөлгөөн хааны зохисон шүлэг маани оршвой»¹¹ хэмээх маани хөгжөөх шүлгийг монгол хэлээр, төвөд үсгээр үсэгчлэн бичсэн байна. Түүнийг энэ маани хөгжөөх шүлгээс гадна өөр бас төвөд үсгээр, монгол хэлээр бичсэн маанийн хоёр, гурван ном бичсэн гэдэг аман мэдээ бий.

Шар цоржийн бичсэн ном зохиолыг ерөнхийд нь ажиглавал бүх зохиолоо шүлэглэн бичсэний зэрэгцээ зохист аялгууны дууны чимгийн доторх Завсардсан хос төгөлдөр чимгийг зохиол бүтээлдээ түлхүү ашиглан бичсэн байна.

¹Tib: rnam 'dren rje btsun dam pa rin po che'i// rnam thar bstod tshig skal bzang dad gsos bzhugs// гар бичмэл, 118 хуудас. Тус намтрыг мөн Түвдэндаржайлин хийдэд барлажээ.

²Tib: rnam 'dren rje btsun dam pa rim byong pa'i// rnam thar gsol 'debs skal ldan dad gsos bzhugs// гар бичмэл, 9 хуудас

³Tib: rnam 'dren rje btsun dam pa'i rnam thar las// rnam 'dren sku phreng gnyis pa'i rnam thar bzhugs so// гар бичмэл, 7 хуудас

⁴Tib: rnam 'dren rje btsun dam pa'i rnam thar las// rnam 'dren sku phreng gsum pa'i rnam thar bzhugs// гар бичмэл, 7 хуудас

⁵Tib: rnam 'dren rje btsun dam pa'i rnam thar las// rnam 'dren sku phreng bzhi'i rnam thar bzhugs// гар бичмэл, 21 хуудас

⁶Tib: rnam 'dren rje btsun dam pa'i rnam thar las// rnam 'dren sku phreng lnga pa'i rnam thar bzhugs// гар бичмэл, 25 хуудас

⁷Tib: rnam 'dren rje btsun dam pa'i rnam thar las// rnam 'dren sku phreng drug pa'i rnam thar bzhugs// гар бичмэл, 3 хуудас

⁸Tib: rnam 'dren rje btsun dam pa'i rnam thar las// rnam 'dren sku phreng bdun pa'i rnam thar bzhugs// гар бичмэл, 3 хуудас

⁹Tib: skyabs gnas mthar thug skyabs mgon brgyad pa la// skyabs 'ch'a gsol 'debs skyabs gnas ngo shes bzhugs// гар бичмэл, 3 хуудас

¹⁰Tib: ma nor lung bstan rje btsun lnga pa che'i// ma 'ongs lung bstan ngo mtshar rmad byung bzhugs// гар бичмэл, 3 хуудас

¹¹Tib: shwa darka thulkeng han nwa tso hya sang/ shu le ga ma ni sel the o rshi ba// монгол модон барын хэвлэл. 2 хуудас

Мөн бидэнд олдоод байгаа бүх зохиолыг гарчгаас нь харахад түүнийх болов уу гэж үзмээр өвөрмөц нэг онцлог байна. Энэ нь юу гэвэл, төвөд шүлэгт 4 шад юм уу 4 мөргийг нэг шүлэг /шлога/ гэж тооцдог. Зохист аялгууны онол ёсоор 2 мөртөөр буюу 2 шүлгээр бичсэнийг хагас шүлэг гэж тооцно. Тэгвэл Шар цорж бүх зохиолоо хагас шүлэглэж гарчигласан нийтлэг онцлог шууд харагдаж байна.

Үүнээс гадна бараг бүх зохиолынх нь мөр бүрд орсон үгийн тоог 9 байхаар, бага таван ухааны эвсүүлэн найруулах ухааны ёсоор магадлан тогтоосон байгаа нь зохиолын гарчгаас эхлээд үндсэн текстэд илэрхий байна. Төвөд зохиолын холбон найруулах аргын онцлог бол мөр бүрд орсон үгийн тоо ижил байх зарчмыг баримталдаг арга юм. Харин монгол шүлэгт үеийн тоо адил байхыг чухалчлахаас илүүтэй толгой, сүүл холбох аргыг түлхүү ашигладаг билээ. Шар цорж ч энэ аргыг зохиол бүтээлдээ ашиглажээ. Тухайлбал, тэрбээр Өндөр гэгээний намтартаа:

ཏཱ་ལ་ཀྲ་ལྷ་འཛིན་མེད་པའི་རྩོམ་པའི་ན། །

སྒྲོན་ཆད་སྲིད་ལས་འདོན་ཐབས་མེད་མོད་གྱུང་། །

བདུག་ནི་རྣམ་ཐར་དྲན་བཞིན་གསོལ་བ་ཏུ་བ་པས།

ན་ལྟ་ཐུགས་རྒྱུ་ལྟ་ཐུགས་ཀྱིས་དང་ཅ་གསོལ། །

Тийм боловч сэнжгүй бөөрөнхий чулуу мэт

Тэмтэрч орчлонгоос гарахын аргагүй боловч

Осолдолгүй **би нь** намтрыг дурдан залбирснаар

Одоо даруйд нигүүлсэхүйн гохоор татан соёрх

хэмээсэн үүний төвөд шүлэгт нь «онжан», «ончад» гэж дуудлагаар нь толгой холбож, монгол хэлний «о» эгшгээр толгой холбосон байхад 3-р мөрд «даг ни», 4-р мөрд «да да» хэмээн монгол хэлний «да» гийгүүлэгчээр толгой холбосон маягтай байдал харагдаж байна. Энэ нь монгол зохиолчийн төвөдөөр бичсэн шүлэгт мэр сэр ажиглагддаг төстэй үгээр толгой холбосон байдлыг санагдуулам зохиомжийн онцлог илэрч байна гэж хэлж болох юм. Мөн үүний жишээ нь:

འདྲེན་མཆོག་སྤྱི་མ་དྲིན་ཅན་ཁྱེད་ཉིད་ཀྱི།

དེཅུ་དྲུག་ཅུང་ཟད་རྣམ་ཐར་བརྒྱུད་པའི་མཁུམ།

འདྲེན་པ་ཁྱོད་ཀྱིས་འབྲལ་མེད་རྗེས་བཟུང་སྟེ།

བདེ་ཆེན་གནས་སུ་འདྲོན་པར་མཛད་དུ་གསོལ།

Удирдагч дээд багш ачит таны

Ачийг санаж намтрыг өчүүхэн өгүүлсний хүчээр

Удирдагч та бээр хагацалгүй даган бариад

Амгалангийн оронд удирдан зохион соёрх!

Монгол хэлэнд «дэн», «дэ» гэсэн авиа ижил төстэй сонсогддог байдлыг бүтээлчээр ажиглаж, «дэ» авиаг давтан толгой холбосон байх бөгөөд үүнтэй адил жишээ цөөн бус ажиглагдаж байна. Энэ нь хэдийгээр Зохист аялгууны 3-р бүлгийн дууны чимэгт үзүүлсэн эгшиг магадлах, орон магадлах чимгүүдтэй адилавтар байгаа боловч тэр чигт нь зохист аялгууны чимгийн дагуу бичсэн гэж бас үзэхийн аргагүй монгол зохиолчийн монгол шүлгийн онцлогийг харуулсан гэж хэлж болохоор байна.

ДҮГНЭЛТ

Төвөд хэлээр ном зохиол туурвисан монгол эрдэмтэн лам нарын нэг болох Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошууны Баян-Овоогийн Шар цорж гэж алдаршсан Дагбажанцан лам нь төвөд, монгол хэлээр шүлэглэн бичсэн олон намтар,

солдэв туурвижээ. Түүний бичсэн 1 боть орчим зохиол нь гар бичмэлээр байхаас гадна Өндөр гэгээний намтар, Шударга дөлгөөн хааны маани зэрэг зохиолыг нь тус хошууны Түвдэндаржайлин хийдэд барласан байна.

Шар цоржийн зохиол бүтээлийн онцлог нь ихэнх тохиолдолд төвөд шүлгийн үеийн тоо тэнцүү байх арга зарчмаар Зохист аялгууны дууны чимгийн дагуу бичсэн байгаа боловч басхүү монгол шүлгийн толгой холбох нийтлэг онцлогийг ч төвөдөөр бичсэн шүлэг зохиолдоо бүтээлчээр ашигласан байна. Үүнээс үзвэл Шар цорж Дагбажанцан нь төвөд хэлний өндөр боловсролтой, Зохист аялгууны онолын арга зарчмыг өөртөө дадуулсан зохиолч байжээ.

Ашигласан ном

Бямбаа, Р. (2004a). *Монголчуудын төвөд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл*. I боть. Улаанбаатар.

Бямбаа, Р. (2004b). *Монголчуудын төвөд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл*. II боть. Улаанбаатар.

Дылыкова, В.С. (2015). *Тибетская агиографическая литература*. Москва: Авторская книга.

Монголын сүм хийдийн түүхэн товчоон (2009). Ерөнхий редактор С. Цэдэндамба. Улаанбаатар: Адмон хэвлэх үйлдвэр.

Омакаева, Э. У. (2010). Письменная традиция. *Калмыки*. Москва: Наука. 382–387.

Отгонбаатар, Р., Цендина, А. Д. (2014). *Образцы письменной традиции Северной Монголии. Алфавиты, транскрипции, языки (конец XVI–начало XX вв.)*. Редактор С.В. Веснина. Москва.

Сонинбаяр, Ш. (1995). Дагважанцан. Тийн удирдагч Жибзундамба их эрдэнийн намтар магтаалын үг сайн хувьтны сүсгийг сэргээгч оршвой. Төвөд хэлнээс орчуулж, эрдэм шинжилгээний тайлбар бичсэн Ш.Сонинбаяр. *Өндөр гэгээний намтрууд оршвой*. Эрхлэн хэвлүүлсэн Ш.Бира, Ш.Сонинбаяр, Д.Дашбадрах. Улаанбаатар.

Сүхбаатар, О. (2001). *Монголын тахилгат уул усны сангийн судар оршвой*. Эмхэтгэн боловсруулж, эрдэм шинжилгээний тайлбар судалгааг үйлдсэн Хатагин Осорнамжимын Сүхбаатар. Редактор проф. Л.Хүрэлбаатар, дэд доктор Ш.Сонинбаяр, Х. Бямбажав. Улаанбаатар.

Туранская, А. А. (2015). «Гурбум» Миларэпы в контексте тибето-монгольской агиографии. *Страны и народы Востока*. 36. 378–402.

Цэрэнсодном, Д. (1988). Монгол ном. «Үнэн» сонин. 02.27.

Шиманская, А. А. (2014). Жанр намтара в тибетской литературе. *Религиоведение*. 3. 110–117.

Gombojab (1959). *Mongyolcud-un töbed kele-ber jokiyaaysan jokiyaal-un jüil* (= Сочинения монголов, писавших на тибетском языке). *Studia Mongolica*. I, fasc. 28. Улаанбаатар: ШУДБХ Эрдэм шинжилгээний хэвлэлийн газар.

Willis, J.D. (1985). On the Nature of rNam-thar: Early dGe-lugs-pa Siddha Biographies. *Soundings in Tibetan Civilization*. B. Aziz and M. Kapstein (eds.). New Delhi: Manohar. 304–319.

References

Byambaa, R. (2004a). *Bibliography of works created in Tibetan language by the Mongols and translated into Mongolian*. Vol. I. Ulaanbaatar.

Byambaa, R. (2004b). *Bibliography of works created in Tibetan language by the Mongols and translated into Mongolian*. Vol. II. Ulaanbaatar.

Dylykova, V.S.C. (2015). *Tibetskaya hagiograficheskaya literatura*. Moscow: Avtorskaya kniga (in Russian).

Gombojab (1959). *Mongyolčud-un töbed kele-ber jokiyaysan jokiyal-un jüil* (= Sochineniya mongolov, pisavshih na tibetskom yazyke). *Studia Mongolica*. I, fasc. 28. Ulaanbaatar: ShUDBH Erdem shinzhilgeenij hevlelijn gazar.

Mongolyn sym hijdijn tyghen tovchoon (2009). Editor-in-chief S. Tsedendamba. Ulaanbaatar: Admon printing house.

Omakaeva, E. U. (2010). Pis'mennaya tradiciya. *Kalmyki*. Moscow: Nauka. 382–387 (in Russian).

Otgonbaatar, R., Tsendina, A.D. (2014). *Samples of the written tradition of Northern Mongolia. Alphabets, transcriptions, languages (late XVI–early XX centuries)*. Edited by S.V. Vesnina. Moscow (in Russian).

Shimanskaya, A. A. (2014). Zhanr namtara v tibetskoj literature. *Religiovedenie*. 3. 110–117 (in Russian).

Soninbayar, Sh. (1995). Dagvajantsan. Tijn udirdagch Zhibzundamba ih erdenijn namtar magtaalyn yg sajn huv'tny sysgijg sergeegch orshvoj. Tövöd helnees orchuulzh, erdem shinzhilgeenij tajlbar bichsen Sh. Soninbayar. *Öndөр gegegenij namtruud orshvoj*. Erhlen hevlyylsen Sh. Bira, Sh. Soninbayar, D. Dashbadrah. Ulaanbaatar.

Syhbaatar, O. (2001). *Mongolyn tahlilat uul usny sangijn sudar orshvoj*. Emhetgen bolovsruulzh, erdem shinzhilgeenij tajlbar sudalgaag yjldsen Hatagin Osornamzhimyn Syhbaatar. Redaktor prof. L.Hyrelbaatar, ded doktor Sh.Soninbayar, H. Byambazhav. Ulaanbaatar.

Tserensodnom, D. (1988). Mongol nom. “Ynen” sonin. 02.27.

Turanskaya, A. A. (2015). “Gurbum” Milarepy v kontekste tibeto-mongol'skoj agiografii. *Strany i narody Vostoka*. 36. 378–402 (in Russian).

Willis, J.D. (1985). On the Nature of rNam-thar: Early dGe-lugs-pa Siddha Biographies. *Soundings in Tibetan Civilization*. B. Aziz and M. Kapstein (eds.). New Delhi: Manohar. 304–319.